



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2022.10.31 № ЦАТ-11/02/024

танай 2022.9.30 -ны № -Т

### Г “СПАРК ЛАЙН” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г Б.ТОГТУУН ТАНАА

Танай компаниас ирүүлсэн гүйцэтгэх захирлыг өөрчлөх тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 6.7-д “Хороо үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтан болон брокер, агентын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн дагуу бүртгэл хийж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ.” гэж заасны дагуу гүйцэтгэх захирал Баясгалангийн Тогтууныг өөрчилж, Цогбаярын Солонгыг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох бүртгэлд бүртгэсэн болно.

Гүйцэтгэх захирал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэнэ үү.

